

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
1.1. Төслийн тухай товч танилцуулга	2
1.2. Баяжуулах үйлдвэрийн байршил.....	2
2. Төслийн талбай, түүний орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч тодорхойлолт.....	4
2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал.....	4
2.2. Байгаль орчин	4
2.2.1. Уур амьсгал.....	4
2.2.2. Амьтны аймаг.....	5
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	5
3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ.....	5
3.2. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ...	5
3.3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ.....	6
3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ	6
3.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ	6
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт.....	7
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	13
6. хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	18
7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	20
8. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	22
9. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	23
10. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	23
11. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	24
12. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	26
13. Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	26
14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА	27

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн тухай товч танилцуулга

“Кевин Инвест” ХХК-ийн хайлуур жоншны хүдрийг флотацийн аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн хүрээнд уг үйлдвэрийг эрдэс түүхий эдээр хангах, хүдэр баяжуулалтын техник, эдийн засгийн үндэслэл боловсруулан хэрэгжүүлэх зорилт тавигдаж байна.

Уг зорилтын хүрээнд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутагт орших хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл хэмээх баримт бичгийг “Молор-Эрдэнэ Арвижих” ХХК боловсруулан Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. ТЭЗҮ-ийн дагуу баяжуулах үйлдвэр дээр бүтээн байгуулалтын ажил хийгдэж, 2008 оноос хүдэр баяжуулах үйлдвэр ажиллаж эхэлсэн.

Энэхүү ТЭЗҮ-ийн тодотголыг Эрдэс баялгийн сайдын 2012 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 74 дүгээр тушаалын 7.3-д заасныг үндэслэн боловсруулав.

“Кевин Инвест” ХХК нь Монгол улсын 9019034023 бүртгэлийн дугаар бүхий гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээ эзэмшдэг бөгөөд хайлуур жоншны хүдэр баяжуулах үйлдвэрлэл эрхлэх эрхийг 2007 оны 09 дүгээр сард авсан. Дорноговь аймгийн Даланжаргалан сумын засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн А/121 тоот шийдвэрээр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 10.8 га газрыг 5 жилийн хугацаатай олгосон. Уг зөвшөөрлийг 2017 онд Даланжаргалан сумын засаг даргын 2017 оны 02 сарын 01 өдрийн А/222 тоот шийдвэрээр 15 жилийн хугацаатай сунгасан.

Хайлуур жоншны баяжуулах үйлдвэр нь анх жилд 75 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтайгаар 2008 онд ашиглалтад орсон ба 2013 оноос үйлдвэрээ өргөтгөн жилд 150 мян.тн хүдэр баяжуулах хүчин чадалтай ажиллаж байна.


“Талст дөл” ХХК нь 2021 оны 11 дүгээр сард тус үйлдвэрийг түрээслэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд бага агуулгатай олборлосон жоншийг худалдан авч баяжуулан 95%-с доошгүй агуулгатай жоншны баяжмал үйлдвэрлэж авто зам, төмөр замаар Үйлдвэр-Олон Овоо өртөө-БНХАУ-ын Эрээн хот гэсэн маршрутаар тээвэрлэнэ.

1.2. Баяжуулах үйлдвэрийн байршил

Газар зүйн байршил: “Кевин Инвест” ХХК-ийн “Хайлуур жонш баяжуулах үйлдвэр” төслийн талбай Дорноговь аймгийн Даланжаргалан сумын 4-р багийн нутагт байрлана.

Хүснэгт 1. Баяжуулах үйлдвэрийн солбилцол

Талбайн булангийн цэгүүд	Х	Ү
1	109° 5'11.5"E	45°55'50.0"N
2	109° 5'16.8"E	45°56'2.8"N
3	109° 5'28.3"E	45°56'0.6"N
4	109° 5'23.0"E	45°55'47.4"N



Зураг 1. Баяжуулах үйлдвэрийн байршил

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Нийгэм эдийн засгийн төлөв байдал

Даланжаргалан сум Ардын хувьсгалын ялалтын дараахан нутгийн захиргаадыг байгуулахад Хан Хэнтий аймгийн Оцол сансар уулын хошуунд харьяалагдаж байгаад 1924 онд БНМАУ-ын Бага хурлын тэргүүлэгчдийн V тогтоолоор “Даланжаргалан сум” нэртэйгээр Боржигон Цэцэн вангийн хошууны нутаг “Элдэв” хэмээх газарт байгуулагджээ. 1931 онд Дорноговь аймгийг байгуулахад тус аймагт харьяалагдан 1957 онд одоогийн төвлөрч байгаа Цомог хэмээх газарт суурьшсан байна. Тус сум 404.5 мян.га газар нутагтай, нутгийнхаа баруун болон хойд талаараа Дундговь, Говьсүмбэр, Хэнтий аймгуудтай, бусад талаараа өөрийн аймгийн Айраг, Иххэт сумдтай хиллэн оршдог. Нийслэл Улаанбаатар хотоос 300 км, аймгийн төв Сайншанд сумаас 156 км-т төвлөрдөг.

Даланжаргалан сум нь засаг захиргааны анхан шатны Элдэв, Өнгөт, Бичигт, Цомог, Олон-Овоо гэсэн 5 нэгжтэй, 2700 хүн амтай, 821 өрхтэй, 126,7 мян.толгой малтай, эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй ба сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар шинээр үүсэн хөгжиж байна. Сумын нутаг дэвсгэрээр Монгол орныг дамжин Ази Европ тивийг холбосон авто болон төмөр зам дайран өнгөрдөг төдийгүй, их хөлийн газар юм. Тус суманд ИТХ-ын ажлын алба, ЗДТГ, 300 гаруй сурагчидтай 9 жилийн болон бага сургууль, эрүүл мэндийн төв, 150 гаруй хүүхэдтэй “Номт ирээдүй” цэцэрлэг, соёлын төв, цагдаагийн хэсэг, Сүгмэл эм эргэлтийн сан, Зэвсэгт хүчний 281-р байгууламж зэрэг төрийн байгууллагууд, болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд байнгын үйл ажиллагаа явуулж байна. Даланжаргалан сум усан болон утаат болор, чүнчигноров, гартаам, мана, өнгөт чулуу, төмрийн хүдэр, хайлуур жонш, нүүрс, хүрмэн чулуу, бал чулуу, шохойн чулуу, барилгын материалын түүхий эд зэрэг ашигт малтмал элбэгтэй.

2.2. Байгаль орчин

2.2.1. Уур амьсгал

Тус сум хүйтэн, хуурай урт өвөл, харьцангуй чийглэг богино зунтай эх газрын эрс тэс уур амьсгалтай, 7 дугаар сард дулааны дундаж хэм 25 градус, 12 дугаар сард 21 градус хүрч хүйтрэх ба хүйтний хугацаа 2 сар үргэлжилдэг, цаг уурын дорнодын мужид хамаардаг.

Урин дулааны улиралд +10 градусаас дээш хугацааны нийлбэр 2000-2800 градус, ургамал өсч хөгжих үе 120-130 хоног байх ба ургамал ургалтын үед 120-170 мм тунадас унадаг. Хур тунадасны жилийн дундаж 165 мм бөгөөд үүний 10 мм нь 11-3-р сард, 155 мм нь 4 -10 дугаар саруудад унадаг бол жилийн туршид гол төлөв баруунаас хүчтэй салхилах бөгөөд салхины хүч нь хавартаа /4-5-р сар/ ширүүсдэг, шороон шуурга болохын өмнө нар хүрээлэн бүдгэрч тэнгэр улбар шар өнгөтэй болдог.

2.2.2. Амьтны аймаг

Нутаг орны байгалийн онцлогоос шалтгаалан тус суманд 35 зүйл хөхтөн, 124 зүйлийн шувуу, 7 зүйл хэвлээр явагчид амьдардаг. Олон зүйлийн шавж, аалз, аалз хэлбэртэн, мөн бусад сээр нуруугүйтний зүйлүүд байдаг.

Ургамлын хувьд цөлөрхөг хээрийн бүлгэмдэл зонхилно. Шарилжны төрлийн ургамлууд түгээмэл тохиолддог ба үүнээс хамгийн элбэг болох агиас шаргал шарилж, олон зүйлийн цэцэгт ургамлаар баялаг.

Тухайлбал: Цахилдаг, сараана, гоо юлт, 2 наст гол гэсэр, сэдэргэнэ, хонгорзул, сөөгөн эмгэн шилбэ, имт гичгэнэ, хатны шар цэцэг, баглуур, өргөст бутаргана, үлтэн могойн идээ, ногоон удвал, улаан бударгана зэрэг ургамлууд элбэг тохиолдох бөгөөд хуурайшилтай жилүүдэд өвслөг болон бутлаг ургамал нилээд тэсвэртэй ургадаг.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн явцад агаарын бохирдол нэмэгдэх, хөрс элэгдэх, ургамлан бүрхэвч талхлагдах, дуу чимээний бохирдолтыг орчиндоо үүсгэх болон хог хаягдал ялгаруулах зэрэг гол сөрөг нөлөөлөл багагүй учрах болно. Эдгээрийн эрчим, үр нөлөө нь төсөл хэрэгжих явцад их боловч нөлөөллийг бууруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг сайтар гүйцэтгэн цаашид хяналт шинжилгээний хөтөлбөрийг зөвлөмжийн дагуу цаг тухайд хийж хэвшвэл гол сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм.

3.1. Агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл түүнийг бууруулах арга хэмжээ

Хүдэр ачих, буулгах түүхий эдийн овоолго болон хүдэр тээвэрлэлт хийх хүнд даацын машин зэргийн нөлөөллөөр их хэмжээний сул шороо дэгдэж агаарт байх нарийн ширхэгтэй тоосонцорын агууламж нэмэгдэх хандлагатай. Хүдэр бутлах, овоолго хийх, ачих зэрэг технологийн процессийн явцад тоос ихээр гарч агаарт дэгддэг. Хүдэр бутлах тээрэмдэх үйл ажиллагаа нь үйлдвэрийн байранд битүү орчинд явагдах тул агаарын чанарт онцгой нөлөө үзүүлэхгүй. Тиймээс тээврийн хэрэгслийн хөдөлгөөн болон үйлдвэрийн талбай дахь хүдрийн овоолгоос хийсэх тоосны нөлөөллийг хяналтанд авч, эрх бүхий байгууллагаас стандартчилж тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давуулахгүй байх тал дээр анхаарч үйл ажиллагаагаа явуулна.

3.2. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглах усны тооцооллоос авч үзэхэд 17 л/сек ус зарцуулж байна. Үйлдвэрт ашиглах өрөмдмөл худгийн 1-3-р түвшний бууралт 12-30 м усны ундарга нь 3-4.8 л/сек байна. Үүнээс үзэхэд жонш баяжуулах үйлдвэрт ашиглах гүний усны нөөц нь хязгаарлагдмал, нөхөгдөх хэмжээ бага зөвхөн улирлын чанартайгаар хур тунадас туйлын бага унадаг, түүнээс үүдэн газрын гүний усны хуримтлал маш удаан бий болдог, байнгын урсгалтай гол, горхи байхгүй зэрэг онцлогийг харгалзан уг төслийн үйлдвэрлэлд зарцуулагдах усны хэмжээ нь гүний усны нөөцөд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Тиймээс тус баяжуулах үйлдвэр нь ашиглах усны хэрэглээг багасгах, дахин ашиглах эргэлтийн системийг боловсронгуй болгох, төслийн үйл ажиллагаанаас гүний

усны нөөц багасахаас урьдчилан сэргийлж байнгын хяналт шинжилгээний ажлыг явуулна.

3.3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Жонш баяжуулах үйлдвэр нь Дорноговь аймгийн Даланжаргалан суманд 2009 оноос одоог хүртэл дулааны улиралд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж ирсэн. Тус үйлдвэрийн эдэлбэр газар нь 1.0 га бөгөөд үүний 65% нь барилгажсан талбай эзэлдэг.

Жонш баяжуулах үйлдвэрийн онцлогоос шалтгаалан үйлдвэрийн талбайд хүнд даацын автомашины хөдөлгөөний эрчимшил их, хүдрийн овоолго бүхий талбай, уурын зуухны нүүрсний талбай зэргээс тоосжилт үүсдэг. Дээрх нөхцөл байдлын үүднээс үйлдвэрийн эдэлбэр талбайн өнгөн хөрс хууларч, суларсан, ургамлан бүрхэвч ихэнхи хэсгээр устсан ба үржил шимгүй хурдас бүхий шороон гадарга үүссэн. Мөн хүнд даацын машин техникийн хөдөлгөөний улмаас хөрс ургамлыг тоосоор дарах, гэмтээх, хөрсийг дагтаршуулах зэргээр талхагдалд оруулсан.

3.4. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Үйлдвэрийн талбайн булан, хашаалсан талбайн захаар хөл газрын ургамал ургасан. Хөл газрын ургамал нь дасан зохицох, мэнд үлдэх чадвар сайтайн дээр шим тэжээлийн бодис ус чийгийг ашиглах чадвар өндөр зэрэг хэд хэдэн давуу талтай байдаг. Тиймээс тухайн бүс нутгийн ургамлын бүлгэмдэлд өөрчлөлт орох нөхцөл бүрдэж болзошгүй юм.

Автомашин техникүүдээс агаарт ялгарах хүхэрлэг хий, азотын болон нүүрсхүчлийн давхар исэл, мөн бусад химийн нэгдэл, нарийн ширхэгтэй тоосны дэгдэлт нь орчны хөрс, ургамлыг бохирдуулан улмаар биоценозод сөрөг нөлөө үүсгэх талтай байж болно.

3.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээ

Жонш баяжуулах үйлдвэр нь Даланжаргалан сумын төвөөс 2 км-ийн зайтай, харьцангуй суурьшлын бүсэд байрладаг тул сээр нуруутан амьтдад шууд сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Харин үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөгөөр хөрсний мизо болон микро фауны амьтдад сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Тус баяжуулах үйлдвэрийн төслийн БОННУ-д тусгасан Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрхзүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, тэдгээр эрх зүйн баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүдэлтэй гэнэтийн осол эрсдэлээс урьдчилан сэргийлж, хүрээлэн буй орчин болоод нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж болох бүх талын арга хэмжээг авч эрүүл аюулгүй, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлж ажиллана.

Тус төлөвлөгөө нь тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны орон зай, цаг хугацааг бүрэн хамарсан байхаас гадна байгаль орчныг хамгаалах талаар авах удирдлага зохион байгуулалтын болон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нөхөн сэргээлтийн арга хэмжээ зэрэг төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, хариуцан гүйцэтгэх эзэн, хэрэгжүүлэх хугацаа ба давтамжийг бодитойгоор тооцож тусгасан.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний хүрээнд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг бүрэн хамарсан.

Энэхүү төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулахдаа “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” -ын дагуу боловсруулсан болно.

2024 оны БОМТ-ний биелэлтийг орон нутгаас томилогдсон ажлын хэсэгт 2025 оны 4-р сарын 08-ны өдөр 90.5%-ийн дүгнэгдсэн. Иймд 2025 оны БОМТ-нд орон нутгаас өгсөн саналын дагуу дараах ажлуудыг оруулав.

Хүснэгт 2. Орон нутгийн ажлын хэсгийн санал

№	Орон нутгаас өгсөн санал	Орон нутгаас өгсөн саналын дагуу хэрэгжүүлэх ажлууд
1	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үйлдвэрийн онцлогт тохируулан бодитой төлөвлөж, сөрөг нөлөөллийг бууруулахад анхаарч, үр дүнг тоо баримттай тайлагнах	Баяжуулах үйлдвэр нь жил бүр БОМТ үйлдвэрийн онцлогт тохируулан бодитой төлөвлөдөг ба биеэлэлтийн тайланд сөрөг нөлөөллийг хэрхэн бууруулсан үр дүн тоо баримттай тайлагнаж ажилладаг.
2	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 10 дугаар сарын 04-ний 58 дугаар зарлигийн дагуу “Тэр бум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд идэвх санаачлагатай оролцож тайлан мэдээ ирүүлэх	“Тэр бум мод тарих” үндэсний хөдөлгөөнийг хүрээнд Даланжаргалан сумын мод тарих талбайд 250ш хайлаас мод тарихаар төлөвлөж байна.
3	Орчны хяналт шинжилгээг хөтөлбөрийн дагуу бүрэн хийлгэж, үр дүнг өмнөх жилүүдтэй харьцуулан дүн шинжилгээ хийж хариу арга хэмжээ авах	2024 оны хөрсний шинжилгээний дүнгээр хүдрийн овоолгоны цэгт As(хүнцэл) болон Mo(молбедин) ЗДХ-нээс их утга заасан. Иймд БОМ тус цэгээс хөрс авч хоёр саванд хуваан хийж, нэг савтай хөрсийг ургамлын үрээр тарьж нөгөө савтай хөрсийг нь малын бууцтай хольсон. Гэвч үр дүнд хүрээгүй.
4	Хүн амын унд ахуйд ашиглаж байгаа усанд улирал тутам 1 удаа, жилдээ 4 удаа шинжилгээ хийлгүүлж байх	ОХШХ-т тусгасан.
5	Хаягдал усны стандартыг хангаж ажиллах	MNS 4943:2015 “Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага” стандартыг хангаж ажилладаг.
6	Хог хаягдал түр хадгалах цэгийг хууль, дүрэм журманд заасны дагуу шаардлагад нийцүүлэх	Баяжуулах үйлдвэрийн хог хаягдал түр хадгалах цэг нь хатуу хучилттай ба ахуйн хог хаягдал, хуванцар сав, хоолны үлдэгдэл, төмрийн хаягдал, ашигласан тос масло, химийн бодисын үлдэгдэл сав баглаа боодол гэж ангилан ялгадаг. 2025 онд зай батерейг нэмэлтээр ангилан ялгахаар төлөвлөөд байна.
7	Тээврийн жолооч нарын байгаль хамгаалах үүрэг хариуцлагыг сайжруулах, ил задгай хог хаях, зориулалтын бус газар засвар үйлчилгээ хийх, маршрутын бус замаар тээвэр хийлгэхгүй байх, тэмдэг тэмдэглэгээг нэмэх, сайжруулах	2025 оны сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан.

8	Тээвэрлэлтээс үүсч буй тоосжилтыг бууруулах арга хэмжээг авч төлөвлөн хэрэгжүүлэх	Тээвэрлэлтээс үүсч буй тоосжилтыг бууруулахын тулд 7 хоногт 2-3 удаа усалгааны машинаар усалгааг тогтмол хийдэг.
9	Авто засвар болон авто зогсоолын талбайн хөрсөнд тос нэвчүүлэхгүй байхаар хайрган буюу бетонон хучилттай болгох ажлыг чанаржуулах	Авто засвар, ашигласан тос масло тор хадгалах цэг нь хатуу хучилттай тул хөрсөнд тос нэвчүүлэхгүй. Мөн авто зогсоол нь хайрган хучилттай ба авто зогсоолын хайрган хучилтыг тогтмол нэмэгдүүлдэг.
10	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хамгаалах болон биотехникийн ажил зохион байгуулан хийхдээ орон нутгаас санал авах, бодитой ажил төлөвлөн хийх	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгаас санал авч 250ш хайлаас болон мод тарих талбайг хашаалхаар төлөвлөгөөнд тусгасан.
11	Ан амьтны байршил, тархалт тоо толгойг тогтоон төслийн үйл ажиллагаанаас учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг орон нутгийн Засаг захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Энэхүү саналын хүрээнд орон нутгийн засаг захиргааны байгууллагатай хамтран ажилах санал дэвшүүлсэн.
12	Зэрлэг ан амьтны усан хангамжийг сайжруулахад зориулан мэдрэгчтэй худаг гаргах, хөв цөөрөм байгуулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх	2024 оны БОМТөлөвлөгөөний хүрээнд Чойрын богд ууланд Чойрын богд уулын ус орж ирэх байршлыг Даланжаргалан сумын байгаль орчны байцаагчийн саналын дагуу 4.5х2м хэмжээтэй 4.5тонн усны багтаамжтай хөвийг байгуулсан.
13	Уул уурхайн үйлдвэрийн бүс дотор болон төвийн цахилгаан шугамаас уурхайн чиглэлд татсан өндөр хүчдэлийн цахилгааны шон дагуу шувуу үргээгч байршуулах	2024 оны БОМТөлөвлөгөөний хүрээнд үйлдвэрийн усан санд 3ш шувуу үргээгч байрлуулсан ба 2025 оны БОМТөлөвлөгөөний хүрээнд үйлдвэрийн цахилгаан шугамд 1ш шувуу үргээгч, төвийн цахилгаан шугамаас үйлдвэр чиглэлд татсан өндөр хүчдэлийн цахилгаан шон дашуу 2ш шувуу үргээгч байрлуулахаар төлөвлөөд байна.
14	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10-1-д заасны дагуу Байгаль орчны аудитыг хуулийн хугацаанд хийлгэн зөвлөмжийн биелэлтийг ирүүлэх	2024 онд аудитын тайланг “Өртөөлөн” ХХК байгаль орчны аудитын мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн.
15	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх /MNS 4219-94/	2025 оны БОМТөлөвлөгөөний удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгасан.
16	Өнгөрсөн онуудад өгсөн зөвлөмж чиглэлийг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлээгүй байгаад онцгой анхаарч хэрэгжүүлж ажиллах	Өмнөх онуудад өгсөн зөвлөмж чиглэлийг төлөвлөгөөнд тусган ажилладаг.

17	Уулзалт, сургалтыг баталгаажуулан хавтас нэгж үүсгэн хадгалах /фото зураг, бүртгэл, материал гэх мэт/	2025 оны БОМТөлөвлөгөөний хүрээнд ажилчдад мэдлэг олгох сургалт зохион байгуулах ба сургалтанд оролцсон ажилчдаар гарын үсэг зуруулж фото зургаар баталгаажуулж биелэлтийн тайланд оруулна.
18	Байгаль орчны чиглэлээр хийгдсэн ажлыг нөлөөллийн бүсийн оршин суугчид, иргэд, сум, багийн ИНХ-д танилцуулж байримтжуулан тайланд хавсаргаж байх	Нөлөөллийн бүсийн оршин суугчдад 4-р улиралд өвс тэжээл олгох үед БОМТ биелэлтийн тайланг танилцуулан ажилладаг.

“Кевин Инвест” ХХК-ийн жонш баяжуулах үйлдвэрийн 2022-2023 оны үйл ажиллагаанд хийгдсэн байгаль орчны аудитын дүгнэлт, зөвлөмж.

Баяжуулах үйлдвэрийн байгаль орчны аудитын тайланг 2024 онд “Өртөөлөн” ХХК гүйцэтгэсэн. Байгаль орчны аудитын ажлыг нийт 104 үзүүлэлтээр дүгнэхэд 92 үзүүлэлт нийцтэй, 2 үзүүлэлт үл нийцтэй, 10 үзүүлэлт дүгнэх боломжгүй байна.

Хүснэгт 3. Байгаль орчны нийцлийн аудитын нэгдсэн үр дүн

№	Аудитын хийгдсэн нэгжүүд	Шалгуур үзүүлэлтийн дүн	Нийцэл	Үл нийцэл	Дүгнэх боломжгүй	Хууль эрхзүйн хамрах хүрээ
1	Агаарын чанар	8	5	0	3	Монгол улсын хууль-2, Монгол улсын стандарт-2
2	Газар ашиглалт	23	23	0	0	Монгол улсын хууль-3, Засгийн газрын тогтоол-1
3	Хөрсний чанар	11	11	0	0	Монгол улсын хууль-2
4	Хог хаягдлын менежмент	17	16	0	1	Монгол улсын хууль-1
5	Ус ашиглалт	11	7	2	2	Монгол улсын хууль 1
6	Биологийн олон янз байдал/амьтан, ургамал/	6	6	0	0	Монгол улсын хууль-4
7	Ашигт малтмалын ашиглалт	9	9	0	0	Монгол улсын хууль-2
8	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	12	9	0	3	Монгол улсын хууль-1 Монгол улсын стандарт-4
9	Химийн хортой болон аюултай бодисын менежмент	7	6	0	1	Монгол улсын хууль-4 Дүрэм-1

Нийт	104	92	2	10	Нийт 104 шалгуурр үзүүлэлт байна
------	-----	----	---	----	--

Хүснэгт 4. Байгаль орчны аудитын зөвлөмжийн биелэлт

№	Зөвлөмж	Биелэлт
<i>Агаарын чанар, физик нөлөөлөл</i>		
1	ОХШХ заасан үйлдвэрийн талбай, хаягдлын далангаас түс бүр жилд 2 удаа SO ₂ , NO ₂ , PM _{2.5} PM ₁₀ тоосонцрыг хэмжүүлэх	2024 онд Дорноговь аймгийн УЦУОШТ гэрээ байгуулан агаарын хэмжилтүүдийг хийлгэсэн. /Үйлдвэрийн бүс, Үйлдвэрийн гадна орчин, Ажилчдын кемп/. ЗДХ давсан үзүүлэлт байгаагүй болно. 2025 онд хаягдлын далан дээр хэмжилт хийлгэхээр төлөвлөлөө.
2	Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамруулах	
<i>Гаар, хөрс ашиглалт</i>		
3	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлангийн хугацаа 2024 онд дууссан.	2024 онд Газрын мэргэжлийн байгууллага болох “Дөрвөнталст экологи” ХХК-аар газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны тайлан хийлгэсэн болно.
4	Нүхэн жорлон хөрс бохирдуулах	Баяжуулах үйлдвэрийн талбайд байх ашигладаггүй нүхэн жорлонг ариутгал хийж булсан болно.
<i>Хог хаягдлын менежмент</i>		
5	Баяжуулах үйлдвэрийн хогийн цэгээс хөрсний эрүүл ахуйн бохирдлыг шинжлүүлсэн шинжилгээний хариунаас үзвэл гэдэсний савханцарын титр, перфрингенсийн таньц дунд зэргийн бохирдолтой гарсан байна.	2024 онд хогийн цэг болон бохирын цооногийг 2 удаа ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн. 2025 оны БОМТ-нд дулааны улиралд дахин эрүүл ахуйн шинжилгээ авхаар тусгасан.
6	Хог хаягдал хуримтлуулах түр цэгийг шинэчлэн, сайжруулах шаардлагатай.	2024 онд баяжуулах үйлдвэрийн хогийн цэгийг цементжүүлж хөрс рүү нэвчхээс сэргийлсэн ба блокоор хашаа өрсөн тул салхинд хийсэн орчин бохирдуулахгүй.
7	Химийн бодисын агуулахыг шаардлагад нийцүүлэн шинэчлэн сайжруулах хэрэгтэй	2024 оны 6 сард химийн бодисын агуулахыг засаж сайжруулсан. Химийн бодисыг тусгаарлагч ханаар тусгаарлаж хадгалж байна. Мөн тэмдэг тэмдэглэгээ, галын аюулаас хамгаалах хэрэгслийг байршуулсан.
8	Аюултай хог хаягдлыг гэрээт байгууллагад хүлээлгэн өгч акт үйлдүүлдэг бөгөөд тосны сав, шуудай зэргийг агуулахаас өөр газар хадгалахгүй байх.	2024 онд химийн бодисын 1.1 тн шуудайг “Цэцүүх трейд” ХХКд нийлүүлсэн. Мөн химийн бодисын үлдэгдэг болох 80л шингэн, 1.6 кг химийн бодисын хуванцар сав, 0.4кг шилэн сав тус тус “Элемент” ХХК тушаасан.
<i>Ус ашиглалт</i>		
9	Үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглаж буй 6 худаг	2025 оны БОМТ-нд тусгасан.

	нь барилгагүй, эрүүл ахуйн бүс тогтоогоогүй байна.	
10	Ус ашиглуулах дүгнэлт жил бүр гаргуулан, гэрээ байгуулж ажиллах, ус ашигласны болон ус бохирдуулсны төлбөрийг тухай бүрт төлөх, төлбөрийн баримтыг хадгалах, архивлах	Жил бүр ус ашиглуулах болон хаягдал усны дүгнэлт гаргуулан гэрээ байгуулан төлбөрийг цаг тухайд нь төлж ажилладаг.
<i>Биологийн олон янз байдал, нөхөн сэргээлт</i>		
11	БОМТ-д тусган хэрэгжүүлэх, орон нутагтай хамтран ажиллах, үйл ажиллагаанаас биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийн эрсдлийг бууруулж байх хэрэгтэй.	2024 оны БОМТ биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Чойрын Богд ууланд 4.5х2м хэмжээтэй хөв цөөрөм байгуулсан.
<i>Баяжуулах үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй</i>		
12	Жонш баяжуулах үйлдвэр нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг зайлшгүй хийлгэх шаардалагатай	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2023 онд хийлгэсэн.
13	Хөдөлмөрийн аюултай, хортой нөхцөлд ажил үүрэг гүйцэтгэдэг ажилтанд хор саармагжуулах бодис, хүнсний бүтээгдэхүүн сүү, аарц, үзэм зэргийг тогтмол олгож, олгосон талаар тэмдэглэл үйлдэн баталгаажуулж байх нь зүйтэй.	Баяжуулах үйлдвэрийн нийт ажилчдад тогтмол зөв аарцыг ХАБЭА ажилтан олгож, баримтжуулан гарын үсэг зуруулан архивлан хадгалдаг.
14	Галын сарайг шаардлагатай газруудад байршуулсан ба сарайны бүрдлийг стандартын дагуу нөхөн бүрдүүлэлт хийх шаардлагатай /MNS 5566:2020/	Галын сарайны байршил: Ажилчдын кемп, ШТС, химийн бодисын агуулах, 1,2 үйлдвэр гэсэн цэгүүдэд байрладаг ба багаж хэрэгслийн нөхөн байршуулсан.

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаар орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр								
1	-Үйлдвэрийн дотоод болон гадаад тээврийн замаас үүсэх тоосжилт -Тээврийн хэрэгслээс гарах хорт утаа	Тоосжилтыг бууруулах төлөвлөгөөт усалгааг 4-10 саруудад хур борооны давтамжаас хамааруулан 7 хоногт 2-3 хийж байх	Дотоод гадаад замууд	м³	-	Дотоод зардалд тусгасан	4-10 сард	MNS 4586:2016 Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага Агаарын тухай хууль, 2012,
2		Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлаж түнд хяналт тавьж байх	Үйлдвэрийн замууд	-	-	Дотоод зардалд тусгасан	2025 он	Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ
3		Машин механизмын засвар үйлчилгээг тогтмол хийх, оншилгоонд хамруулах. Чанартай түлш ашиглаж байх хэрэгтэй.	Үйл ажиллагаанд ашиглагдах машин механизм	сар/жил	-	Дотоод зардалд тусгасан	2025 он	MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх

4		Олон шинэ салаа зам үүсгэхгүй байх, замыг тэмдэгжүүлэх, хуучирсан тэмдэг тэмдэглэгээг сэргээх	Баяжуулах үйлдвэрийн зам	ш	10	300,000	2025 он	хэрэгсүүдийг хэрэглэх дүрэм
Газрын гадрага, Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
1	Хаягдлын санд шүүрэлт үүссэнээр орчны хөрсийг бохирдуулах	Хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг ханган үйл ажиллагаа явуулах, хяналт мониторинг тогтмол хийж байх	Хаягдлын сан	төг/жил	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгах		2025 он	MNS 5916:2008 (Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт)
2		Аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг баримтлан үйл ажиллагаа явуулах	Хаягдлын сан	төг/жил	Орчны хяналт шинжилгээний зардалд тусгах		2025 он	
3	Газрыг зөвшөөрөлгүй ухаж, сэндийчлэх, олон салаа зам үүсгэснээр хөрс эвдрэх	Олон салаа зам гаргахгүй байх нөхцлийг хангах, тээврийн замыг тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулах	Тээврийн зам	200,000			2025 он	
4	Ахуйн бохир хадгалах цооног, шугам хоолойд гэмтэл гарсны улмаас хөрс	Бохир хадгалах цооног, шугам хоолойд тогтмол хяналт шалгалт хийж, эвдрэл гэмтэл гарсан	Ахуйн бохир хадгалах цооног, бохир дамжуулах шугам хоолойд	Үйл ажиллагааны зардалд тусгасан			2025 он	MNS 5924:2015. Нүхэн жорлон угаадасны нүх техникийн шаардлага

	бохирдож болзошгүй	тохиолдолд нэн даруй засах арга хэмжээ авах						
5	Машин тээврийн хэрэгслүүдийн явах эд ангиуд гэмтэх, хүний болгоомжгүй үйлдлээс ШТМ гоожиж, асгарсан тохиолдолд тухайн орчмын хөрсөн бүрхэвчийг бохирдуулж болзошгүй	Гоожиж, асгарсан ШТМ-ыг шингээх материалыг ажлын талбайд бэлэн байлгах, мөн асгаралтаас сэргийлэх, асгаралтын үед авах арга хэмжээ, асгаралтыг мэдээлэх, хязгаарлах, цэвэрлэх дотоод журам боловсруулж, мөрдүүлж ажиллах	Хөдөлгөөнд оролцож буй бүх тээврийн хэрэгсэл	Үйл ажиллагааны зардалд тусгасан				Сонгож авсан шингээгч материалгыг хэрэглэх зааварчилгаа ШТМ асгаралтаас урьдчилан сэргийлэх, хязгаарлах талаар баримталж буй уурхайн дотоод дүрэм, журам
6	Ахуйн болон бусад хог хаягдлыг зориулалтын бус газарт хаях, зориулалтын бус саванд хадгалах зэргээс хөрс бохирдож болзошгүй	Хог хаягдлыг зориулалтын цэгт хаях, ангилах ялгах зориулалт бүхий хогийн савнуудыг хэрэгцээт газруудад байршуулах	Хогийн цэг, хогийн савнууд хамаарна	Хог хаягдлын зардалд тусгасан				Хог хаягдлын тухай Монгол улсын хууль
Гадаргын болон газар доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр								
1	Ус ашиглах боломжит нөөцийн	Тоолуурын баталгаажуулалтын цаг тухай бүрт нь	Баяжуулах үйлдвэрийн гүний худаг	ш	-	500,000	Эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны

	тооцоонд тусгагдсаны дагуу ариг гамтай ашиглах	хийлгэх, тоолуур эвдрэл гэмтэл гарсан тухай бүр солих						тухай хууль -ЗГ-ын 2009 оны 351 дүгээр тогтоолын хавсралт-Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээ.
2		Худгийн тоолуурын мэдээг сар бүр суманд тайлагнах	Баяжуулах үйлдвэрийн гүний худаг	Дотоод зардалд тусгасан			Сар бүр	
3		Унд ахуйн болон бусад хэрэгцээнд усыг ариг гамтай, алдагдал багатайгаар ашиглах, ус хэмнэлтэт эко цорго нэвтрүүлэх	Ус ашиглах цэгт	ш	5	2,500,000	2025 он	
4		Хур борооны усыг хуримтлуулан тоосжилт, зам усалгаа, ногоон байгууламж услахад ашиглах	Ус ашиглах хэсэгт	Дотоод зардалд тусгасан			4-10 сар	
5		Худгийн барилга байгууламжийг сайжруулах, эрүүл ахуйн бүс тогтоох	Усны эх үүсвэр	Дотоод зардалд тусгасан			2025 он	Усны тухай хууль 22.1
6	Хаягдлын сангаас ус шүүрэн гарах мөн ахуйн бохир хөрсөнд алдагдсанаас газры доорх ус	Хаягдлын сангийн аюулгүй ажиллагааг ханган үйл ажиллагаа явуулах	Хаягдлын сан бохир хадгалах цооног	Дотоод зардалд тусгасан			2025 он	
7		Бохир хадгалах цооног, шугам хоолойд тогтмол					2025 он	

	бохирдож болзошгүй	хяналт шалгалт хийж, эвдэрэл гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй засах арга хэмжээ авах					
Ургамал нөмрөг, амьтны аймгийг хамгаалах чиглэлээр							
1	Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устах	Баяжуулах үйлдвэрийн ургамлын аймгийг тодорхойлох цэгт ургамлын мониториг хийх	Баяжуулах үйлдвэрийн ойр орчин	2 цэгт 1 удаа	100,000	6 сараас 8 сарын хооронд	Ургамлын мониторнг хийх аргачлал (шугаман цэгийн арга)
Амьтны аймагт нөлөөлөх нөлөөллийг бууруулах чиглэлээр							
1	Хууль бусаар ан амьтан агнах, шөнө оройн цагаар гэрэл чийдэн тусгаж сэлгүүцсэнээр ан амьтан дайжих	Хууль бусаар ан амьтан агнах, гаршуулах, гэрэл чийдэн тусгаж сэлгүүцэж амьтадыг айлгах, хөөн зайлуулах үйлдлийг хатуу хориглоно. Ажилчдад мэдлэг олгох сургалт хийх	Мал амьтан	Дотоод зардалд тусгасан		2025 он	Амьтны тухай хууль, 2012 6.1.7.үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх;
2		Үйлдвэрийн цахилгаан шугам болон сумаас үйлдвэр чиглэлийн өндөр хүчдэлд шувуу үргээгч байршуулах	Өндөр хүчдэл	2 ш	100,000	2025 он	
Нийт зардал:						3,500,000	

6. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөн нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн	Ахуйн хог хаягдлыг орон нутгаас заасан цэгт тээвэрлэн зайлуулах	Баяжуулах үйлдвэрээс гарах хатуу хог хаягдал Гэрээний дүнгээр			Хог хаягдлын тухай хууль, ангилан ялгаж хаях журам, дотоод дүрэм журам
	Хүнсний хог хаягдлыг ялган авч түргэн ялзруулагч ашиглан компост бордоо хийж хүлэмжийг бордох				
	Хог хаягдлын гэрээ байгуулах, төлбөр хураамжийг цаг тухайд нь төлөх				
	Ахуйн бохир усны цооногт ариутгах, халдваргүйжүүлэх, ариутгах.				
		Бохир усны цооног	200,000		
Хаягдал ус	Үерийн болзошгүй аюулаас хамгаалагдсан байх	Үйл ажиллагааны зардалд тусгасан			
	Хаягдал усны хяналт шинжилгээ мониторингийг цаг тухайд хийх				
Аюултай	Ашигласан тос масло хадгалах цэгийн бүрэн бүтэн байдлыг хангах	Ашигласан тос масло хадгалах цэг	Үйл ажиллагааны зардалд тусгасан		
	Ашигласан тос маслийг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Ашигласан тос, Хөргөгч шингэн Тостой холилдсон ус	Гэрээний дүнгээр (Клийн Ойл ХХК)		

Химийн бодисын шингэн үлдэгдэл болон сав баглаа боодлыг мэргэжлийн байгуулгатай гэрээ хийж зайлуулах	Гэрээний дүнгээр (Элемент ХХК / Цэцүүх трейд ХХК)	Хог хаягдлын тухай хуулийн 5- р бүлэг 23- р зүйл
Ашиглалт дууссан эд ангийг тусгай талбайд хадгалан хаягдал төмрийг дахин боловсруулах үйлдвэрт хүргүүлэх	Гэрээний дүнгээр	
Нийт		2,500,000

7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр						
1	Ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох,	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	Үйл ажиллагааны зардалд тусгасан		2025 он	MNS 4990:2000
2		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх			2025 он	MNS 4969:2000
3		Ажиллагсдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах			2025 он	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 15-р зүйл
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр						
4	Хүчтэй салхи шуурганаас аюул, осол гарах	Хүчтэй салхи, шуурга үед аян замд гарахгүй	Төслийн талбай болон түүний ойр орчимд	ҮАЗ	2025 он	
5		Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг хангах	Үйлдвэрийн ажилчид	ҮАЗ		
6	Гал түймрийн улмаас үйл ажиллагаа доголдох, зогсох	Гал унтраах багаж хэрэгсэл хүрэлцээтэй хэмжээгээр	Үйлдвэрийн байр сууц	ҮАЗ		

		байрлуулах, галын хорны даралт, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянах				
7		Галын дүгнэлтийг мэргэжлийн байгуулгаар гаргуулах		30,000		Галын аюулгүй байдлын тухай хууль
Нийт зардал:				2,500,000		

8. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ	Тоо хэмжээ	Зардал /төг/	Хэрэгжүүлэгч	Баримтлах хууль, журам, стандарт
1	Даланжаргалан сумын төв замын ард байрлах мод тарих талбайг тойруулан хашаа барих	840м хашаа	7,000,000	“Кевин Инвест” ХХК	MNS 6140:2010 Мод, сөөгний тарьц. Техникийн шаардлага
	Даланжаргалан сумын мод тарих хашаалсан талбайд мод тарих	2-3 настай 250ш хайлаас	2,000,000	“Кевин Инвест” ХХК	
Нийт зардал			9,000,000		



Зураг 2 Хашаа барих болон мод тарих талбай

9. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаагаар газар чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх ажил явагдахгүй.

10. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төмрийн хүдрийг хуурай соронзон аргаар баяжуулах үйлдвэрийн төслийн барилга байгууламжуудыг барьж байгуулах, тэдгээрийг ашиглахад Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт буй улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудад шууд сөрөг нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд барилга байгууламжуудыг барьж байгуулах, төслийн үйл явцад ямар нэг түүх соёлын дурсгалын шинжтэй зүйл илрүүлсэн тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 17.11-ийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт- шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Зардал төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар				
Агаарын бохирдлын цэгэн эх үүсвэр: TPS, PM2.5,PM10, SO2, NO2	Ажилчдын байр Үйлдвэрийн бүс Хаядлын далан	Жилд 2 удаа	390,000	Дээжлэхдээ MNS 4585:2007, MNS:3384:1982 MNS:4048:1988–г баримтлах
Гадаргын болон газрын доорхи ус				
Гүний худгийн усны чанар: pH, TDS, нийт хатуулаг, ууссан хүчилтөрөгч, БХХ, ХХХ, Ca, Mg, Na, K, SO ₄ , NO ₂ , NO ₃ , NH ₄ , As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni,	Гүний худаг	Улиралд 1 удаа	180,000	MNS (ISO) 5667- 5:2001- усны чанар- дээжлэлт
Ахуйн бохир усны цоонгийн бохир ус: pH, Ж/б, ХХХ, БХХ, NH ₄ , NO ₂ , NO ₃ , N-нийт, P- эрд	Ахуйн бохир усны цооногт	Жилд 2 удаа	180,000	MNS (ISO) 5667- 10:2001 “Усны чанар.дээж авах. 10-р бүлэг. Хаягдал уснаас дээж авах заавар”
Хөрсөн бүрхэвч				
Хөрсний бохирдол, ялзмагийн агууламж: pH,, чийгшил, ялзмаг, NH ₄ , NO ₃ , SO ₄ , P ₂ O ₅	Үйлдвэрийн бүс Кемп Харьцуулах хөрс	Жилд 2 удаа	411,000	MNS 0900:2018 Ундны усны эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ
Хөрсөнд агуулагдах хүнд металлын агууламж: Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr	Кемп Энгийн хог хаягдал Засварын төв Химийн хог цуглуулах Хүдрийн овоолго Баяжуулах үйлдвэр ШТС	Жилд 2 удаа 7 цэгт	180,000	MNS 6561:2011 ариутгах татуургад нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага.
Ургамал				
Ургамлын зүйлийн бүрдэл,	Үйлдвэрийн талбай орчимд 1 цэгт,	Жилд 1 удаа	300,000	

ургамлын тусгаг бүрхэц, арви, 1 м2 талбайгаас газрын дээрх биомасс авах	Ногоон байгууламж байгуулсан талбай зам дагууд 1 цэгт,			
Амьтан				
Эргэлийн усан болон хаягдлын санд ирж буй шувууд, тэдгээрийн төрөл, тоо, давтамжийн хаянах, бүртгэл хөтлөх	Эргэлтийн усан сан болон хаягдлын санд	Дулааны улиралд сард 2 удаа	ҮАЗ	
Дуу чимээ				
Дуу чимээний түвшинг хэмжих	2 цэгт	Жилд 2 удаа	ҮАЗ	
Нийт зардал:			2,300,000төг	

12. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжүүлэх хуваарь	Зардал /төг/	Хариуцсан албан тушаалтан
1	Газар, ус, агаар бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулах		Гэрээний дүнгээр	Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч
2	Баяжуулах үйлдвэрийн ажилчдыг гэнтийн ослын даатгалд хамруулах	1-р улиралд багтаан гэрээ хийх	500,000	Хүний нөөцийн мэргэжилтэн
3	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31.1.6 заалтын дагуу Экологийн паспорт хөтлөх			MNS 4219-94
Нийт зардал			2,000,000	

13. АЙМАГ, СУМЫН ОРОН НУТГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ШААРДЛАГААР ХИЙСЭН АЖИЛ БОЛОН НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	БОМТ-ийн хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцсан зохион байгуулах ажилтан
1	БОУАӨЯ-д	Цахим хэлбэрээр	2025 оны БОМТ-ний биелэлтийн хүрээнд хийсэн ажил	2025 оны 4-р улирал	-	Байгаль орчны мэргэжилтэн
2	Орон нутгийн байгаль орчны байцаагч болон багийн иргэд	Бичгэн тайлан		2025 оны 4-р улирал	100,000	Байгаль орчны мэргэжилтэн
3	Аймгийн байгаль орчны газарт	Шинжээчийн дүнгээр баталгаажна		2025 оны 4-р улирал	100,000	Байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал				200,000		

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний задаргаа	Зардал
1	Сөрөг нөлөөллийн буруулах арга хэмжээ	3,500,000
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,500,000
3	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	2,500,000
4	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	2,000,000
4	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	7,000,000
5	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Түүх соелын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
7	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,300,000
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	2,000,000
9	Аймаг, сумын орон нутгийн төрийн захиргааны байгууллагын шаардлагаар хийсэн ажил болон нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	200,000
Нийт		22,000,000 төг